



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 01/22

Улаанбаатар хот

Хүний нөөцийн бодлого төлөвлөлт,
үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай.

“Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын эрүүл мэндийн сайд нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай хийсэн хамтран ажиллах гэрээ, Нийслэлийн 2022 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө”, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2022 он 11 сарын 11-ний 1644 тоот “Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” албан тоотыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг эрчимжүүлж сувилагчийн тоог нэмэгдүүлэх, сэлгэн ажиллуулах, зээл тусламжид хамруулах, албан хаагчдыг гадаад, дотоодод суралцах боломжоор хангах ажлын хүрээнд хийгдсэн тайланг тухай бүр заасан хугацаанд хүргүүлж, туршлага солилцох өдөрлөг хийх, хүний нөөцийн тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэн 2022 оны жилийн эцсийн тайланд тусган доорх чиглэлээр ажлыг эрчимжүүлэх ажиллахыг Хүний нөөцийн албаны бүрэлдэхүүнд даалгасугай.

2. Тус эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн албаны бүрэлдэхүүнд даалгах нь:

2.1 Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, дүүргийн эмнэлгийн мэргэжилтэнг лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад дадлагажуулан сургах, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын эмнэлгийн мэргэжилтэнг оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад сэлгэн ажиллуулах арга хэмжээг дэмжиж ажиллах; Дүүргийн Эрүүл мэндийн төвүүд Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас хамгийн багадаа 10 эмч, мэргэжилтнийг богино хугацаагаар өөрийн төв дээр ажиллангаа дадлагажуулах ажлыг зохион байгуулж чадавхжуулах.

2.2 Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн

3 170 7032206

мэргэшил эзэмших, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд харьяалах дүүргийн алслагдсан анхан шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлага болон ажилтнуудад ур чадварыг сургалтыг оруулах.

2.3 Дүүргүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан ажиллаж буй сувилагчийн тоог нэмэгдүүлж, эмч, сувилагчийн харьцааг 1:2-т хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд улсын болон байгууллагын захиалгаар жилд сувилагч, туслах сувилагч мэргэжлээр 3-4 суралцагчийг шинээр сургах зардлыг шийдвэрлэж ажиллах.

2.4 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллах ажлын хүрээнд дүүргийн болон нэгдсэн эмнэлгүүд үндсэн мэргэжлийн сургалт эрхлэгч байгууллага болох.

2.5 Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийг хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг тусалцаа үзүүлж тухайн оролцсон арга хэмжээний тайлан болон хяналт, явцыг тухай бүр тайлагнах.

2.6 Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг гадаадад урт хугацааны сургалтад хамруулах ажлын хүрээнд хийгдсэн тайланг тухай бүр заасан хугацаанд хүргүүлж туршлага солилцох өдөрлөгийг хийж ажиллах.

2.7 Дүүрэг бүрд эрэгтэйчүүдийн кабинет байгуулж ажиллах ажлын хүрээнд эрэгтэйчүүдийн эмчийг сургаж бэлдэх.


2.8 Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг цалин урамшуулалтай уялдуулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлж ажиллах.

2.9 Хүний нөөцийн тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээг тус бүр хэрэгжүүлж үр дүнд хүрч ажилласан байх.

3. Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажил хангах хүрээнд архив бичиг хэргийн бүртгэл, хадгалалт зэрэгт шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Архив бичиг хэргийн ажилтан /Дулмаа/, Хүний нөөцийн ажилтан /Б.Энхчимэг/, /Д.Бат-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /Ц.Энхбаясгалан/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ